



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 117

Номгон

Г Уул уурхайн ашиглалтын чиглэлээр Г
2020 онд үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжүүдийн
хандив дэмжлэгийн доод хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Уул уурхайн ашиглалтын чиглэлээр 2020 онд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдээс нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт үзүүлэх хандив дэмжлэгийн доод хэмжээг хавсралтад дурдсанаар баталсугай.

2. Аж ахуй нэгжүүдтэй байгаль орчныг хамгаалах, уул уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх талаар гэрээ байгуулж, хандив дэмжлэгийн 70 хувийг аймгийн Орон нутгийн хөгжлийн санд, 30 хувийг тухайн сумын Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190195

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 27-ны
өдрийн 117 дугаар тогтоолын хавсралт



УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР 2020 ОНД
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН
ХАНДИВ ДЭМЖЛЭГИЙН ДООД ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ

№	Аж ахуйн нэгжийн нэр	Хандивын хэмжээ	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд	Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд
1	2	3	4	5
1	Одод гоулд ХХК	100,000,000.0	70,000,000.0	30,000,000.0
2	Монгол болгар гео ХХК	50,000,000.0	35,000,000.0	15,000,000.0
3	Эрдэнэцагаач ХХК	50,000,000.0	35,000,000.0	15,000,000.0
4	Вояжир минерал ресурс ХХК	300,000,000.0	210,000,000.0	90,000,000.0
5	Ай эн Ди ХХК	60,000,000.0	42,000,000.0	18,000,000.0
6	Мөнхийн номхон далай	60,000,000.0	42,000,000.0	18,000,000.0
7	Шижир аранжин ХХК	220,000,000.0	154,000,000.0	66,000,000.0
8	Топ ган дриллинг ХХК	200,000,000.0	140,000,000.0	60,000,000.0
9	Жи Эс би ресурс ХХК	110,000,000.0	77,000,000.0	33,000,000.0
10	Эл ти Ди ХХК	50,000,000.0	35,000,000.0	15,000,000.0
11	Наран мандал Энтерпрайзес ХХК	315,000,000.0	220,500,000.0	94,500,000.0
12	Эрдэнэмонгол ХХК	200,000,000.0	140,000,000.0	60,000,000.0
Нийт дүн		1,715,000,000.0	1,200,500,000	514,500,000

ооо